



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОЛОВСРОЛ  
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 4/06

Баян-Өндөр сум

Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай

Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” 01 дүгээр албан даалгавар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн гишүүд, хүүхдээ хамгаалахад хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор байгууллагын эцэг эхийн зөвлөлийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Эцэг эхийн зөвлөлийн дарга:

М.Сэлэнгэ

(Тэгш боломж, хүүхдийн хөгжил, хамгаалал, дотуур байр, сурах бичиг, сургалтын орчин хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Л.Тайвантуул

(Сургуулийн өмнөх боловсрол, хариуцсан мэргэжилтэн)

П.Одончимэг

(Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн)

2. Байгууллагын ажилтнуудын ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл байдлын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хүүхэд хамгаалалтай холбоотой хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

О.АРИУНГЭРЭЛТ

